

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

МОН 2023 оны 8/305

Дагаж мөрдөх огноо:

2023.10.02.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.10.02.

Байгууллагын нэр:

Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв

Албан тушаалын нэр:

Дуудлага хяналтын бага эмч

Ажлын цаг:

24 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн бус

Нэгжийн нэр:

Нийгмийн Эрүүл Мэнд, Тандалт, Шуурхай
Удирдлагын Алба

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ -4

Ажлын байрны албан ёсны байршил:

СХД-ийн 20-р хороо

Онцгой нөхцөл:

Хортой

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Дуудлагын үеийн бэлэн байдлыг хангаж, зоонозын өвчний сэжигтэй дуудлагын мэдээллийг шуурхай хүлээн авч хариу арга хэмжээг хэрэгжүүлэх

1. Зоонозын өвчний дуудлагын бэлэн байдлыг хангах
2. Өвчлөлийн сэжигтэй тохиолдол гарсан үед шуурхай мэдээлэл хүлээн авч хариу арга хэмжээг хэрэгжүүлэх
3. Үйл явдалд суурилсан тандалтын болон яаралтай дуудлагын тусламж үйлчилгээнд хөтлөгдөж байгаа анхан шатны бүртгэл маягтын хөтлөлтийг ханган ажиллах
4. Дуудлагын үеийн болон ажлын бус цагаар дэглэмийн зөвшөөрлөөр ажиллагсдын цаг ашиглалтад хяналт тавих, вакцины хүйтэн хэлхээг хянах
5. Тусламж үйлчилгээний чанарын тасралтгүй байдлыг хангах, аюулгүй байдал, алдаа зөрчил, эрсдэлээс сэргийлж ажиллах
6. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	- Холбогдох заавар журмын дагуу яаралтай дуудлагын бэлэн байдлын 24 цагийн туршид ханган сонор сэрэмжтэй ажиллах - Дуудлагын үеийн шуурхай байдал, эм, хэрэгсэл холбооны бэлэн байдлыг хангуулах	-Дуудлагын бэлэн байдлыг хангах тухай тушаал, заавар -Дуудлагын багийн сарын хуваарь -Нөөцийн жагсаалт -Багийн гишүүдийн үүрэг	Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	- Хүн ба мэрэгч амьтны дуудлагыг хүлээн авч хариу арга хэмжээг зөв шуурхай авч хэрэгжүүлэх - Яаралтай дуудлагын тусламж үйлчилгээнд хөтлөгдөж байгаа анхан бүртгэл маягтыг бүрэн зөв хөтлөх - Аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг хүлээн авах, эргэн мэдээллэх	- Сэжигтэй дуудлагын бүртгэл хөтлөлт -АШБМ-ыг стандартын дагуу бүртгэх, ТСХ, тоон, цахим, ZIS программын бүртгэл -ЭМБ-аас мэдээлэсэн мэдээллийг дамжуулсан ТСХ-т тэмдэглээ, хөтлөлт	Г Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	- Үйл явдалд суурилсан тандалтын мэдээ түүх, цэгцлэх, шивэх, тандалтын эмчийг мэдээллээр хангах - Лабораторийн эмч нараас холбогдох мэдээллийг авч (сорьц, шинжилгээний хариуны тухай явц, дүнг) эргэн мэдээлэх - Дуудлага хяналтын жижүүрийн хариуцах анхан шатны бүртгэл маягтыг зөв бүрэн хөтлөх	-Үйл явдалд суурилсан мэдээний шивэлт -Эргэн мэдээллийн бүртгэл -Мэдээ тайлан төлөвлөгөөг заасан хугацаанд нь нэгтгэж тайлагнах	Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	- Дуудлага хяналтын жижүүрийн хуваарийн дагуу ажиллах - Байгууллага уруу орж, гарч буй хөдөлгөөн болон тухайн өдөр жижүүр эмчтэй холбоотой шийдвэрлэх асуудлыг зохион байгуулж, бүртгэх, зохицуулах - Вакцин, ийлдсийн хүйтэн хэлхээнд хяналт тавих, шаардлагатай үед вакцин ийлдсийг хүргүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	-Дуудлага хяналтын жижүүрийн хуваарь -Жижүүрийн тэмдэглэл -Вакцин, ийлдэсний хүйтэн хэлхээнд хяналт тависан бүртгэл	Г Г Г

5 дугаар зорилтын хүрээнд	- Ажлын бус өдрүүдэд лабораторийн туршилтын амьтныг хооллох - Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал, чанар, биохамгаалал, биоаюулгүй байдлыг хангаж, алдаа зөрчил, эрсдэлээс сэргийлж ажиллах - Ажлын байрны эрсдэл үүсч болох нөхцөл байдлыг үнэлэн, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч ажиллах.	- Вибарын амьтдын хооллосон бүртгэл, тэмдэглээ - Мөрдөгдөх хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, зөрчил гаргахгүй байх	Г Г Г
6 дугаар зорилтын хүрээнд	- Байгууллагаас зохион байгуулж буй соёл, олон нийтийн арга хэмжээнд оролцох - Өөрийн мэдлэг, мэргэшил, хууль эрх зүйн мэдлэгээ байнга дээшлүүлэх, сургалтад хамрагдах - Байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц санал, санаачилга гарган хэрэгжүүлж ажиллах	- Олон нийтийн ажилд оролцсон удаа - Хамрагдсан сургалтын тоо - Шинэ санаачлагын тоо	Г Г Г
Ажлын үндсэн хариуцлага	1. Нийтийн ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх 2. Хуулийн хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн чанартай хийж гүйцэтгэх 3. Ажлын цагийг үр бүтээлтэй баримтлан ажиллах 4. Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны өдөр тутамын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох 5. Байгууллагад мөрдөгдөж буй бүхий л стандарт, журам зааварыг баримтлан үнэн зөв гүйцэтгэх 6. Өвтөн болон үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах 7. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан хэрэгжүүлж ажиллах 8. Өөрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, эд зүйлсийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах		
Ажил гүйцэтгэхэд олгосон эрх	1. Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны өдөр тутамын үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бичгийн хэрэгслээр хангуулах 2. Мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдах, өөрийгөө хөгжүүлэх, эрдэм судалгаа шинжилгээний ажилд оролцох 3. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр өөрийн ажлын онцлог болон мэргэжлийн зүгээс санал оруулах, шийдвэрлүүлэх 4. Тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг шаардлагатай эх үүсвэрээс гаргуулан авах 5. Хийсэн ажлын үр дүнгээр урамшуулалд хамрагдах 6. Хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл ЗГ-аас тогтоосон бусад тэтгэлэг урамшуулалд хамрагдах 7. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангуулах		

	8. Байгууллагад тулгамдсан асуудал, удаан хугацаанд шийдвэрлэгдэхгүй байгаа асуудлаар санал боловсруулан бүх шатны удирдлагуудад танилцуулах
Орлон, хавсран ажиллах албан тушаал	
Шаардлагатай тохиолдолд бусад бага эмч нарыг орлон буюу хавсран ажиллана.	



III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дипломын буюу бакалаврын боловсролтой байх
Мэргэжил	Ерөнхий мэргэжлийн лаборант, сувилагч, бага эмч
Мэргэшил	
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	-Ажлын эмх цэгцтэй, -Анхаарлаа төвлөрүүлэх, дэс дараатай шургуу ажиллах, нягт нямбай хичээнгүй зан чанартай байх -Багаараа ажиллах, бусад зааж сургах чадвартай байх -Ярианы болон харилцаа, хувийн өндөр соёлтой -Ажлын цагийг баримталдаг -Үнэнч шударга байх -Манлайлах

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект 1. Орон нутгийн ЗӨСТөв . 2. Бусад төв эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төв 3. Төрийн болон төрийн бус бусад байгууллага

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
ЗӨСҮТөвийн ерөнхий захирал Н.Цогбадрах  /гарын үсэг/ 2023 оны 09 сарын 04 ны өдөр	Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга Л.Роломжав  /гарын үсэг/ 2023 оны 10 сарын 02 ны өдөр	Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дуудлага хяналтын бага эмч Я.Ягаанхүү  /гарын үсэг/ 2023 оны 10 сарын 04 ны өдөр